Батлав:

Баянтээг ХК -ийн

Гүйцэтгэх захирал...../Ц.Базаррагчаа

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯНТЭЭГ ТӨХК
1023050010+2014491

БАЯНТЭЭГИЙН НҮҮРСНИЙ ОРДЫГ АШИГЛАХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

1. **Оршил**
   Энэхүү техник эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэснээр Баянтээгийн нүүрсний ордыг эдийн засгийн үр ашигтай ашиглах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологи шинэчлэл хийх зэрэг уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэхэд гол зорилго оршино.
2. **Үндэслэл**
   Ил аргаар ашиглах боломжтой эдийн засгийн хувьд үр өгөөж өгөх ил уурхайн хүрээ хязгаарын тооцох, түүнийг төлөвлөх, төлөвлөлттэй холбоотой тооцооллыг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулж ТЭЗҮ-д тусгах.
3. **Ажлын зорилго**
   Баянтээгийн ордын ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг холбогдох хууль журмын дагуу боловсруулж ЭБМЗ-өөр батлуулах
4. **Судалгааны ажил гүйцэтгэх талбай**
   Нүүрсний орд газар нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд байрлах Баятээгийн нүүрсний ил уурхай болно.
5. **Ажлын үүрэг хуваарь**
   Доорх бүлгүүдийн хүрээнд нарийвчилсан судалгаа тооцоог боловсруулж бүх тооцоо судалгааг мэргэжлийн албан ёсны эрхтэй программ хангамжаар боловсруулж захиалагчид 3 хэмжээст байдлаар хүлээлгэн өгөх.
   - БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН
   - БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
   - БҮЛЭГ III. ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТҮҮХ, ОРДЫН ГЕОЛОГИЙН ТОГТОЦ
   - БҮЛЭГ IV. ОРДЫН НӨӨЦИЙН ТООЦОО
   - БҮЛЭГ V. ИЛ УУРХАЙ
   - БҮЛЭГ VI. УУРХАЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ
   - БҮЛЭГ VII. УУРХАЙН ДЭД БҮТЭЦ
   - БҮЛЭГ VIII. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БОДЛОГО, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
   - БҮЛЭГ IX. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

- БҮЛЭГ X. БАЙГАЛЬ ОРЧИН, УУРХАЙН ХААЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТ
- БҮЛЭГ XI. НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА
- БҮЛЭГ XII. ТӨСЛИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

6. Ажил гүйцэтгэх хугацаа

Гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор ТЭЗҮ-ийг боловсруулж ЭБЗМ-өөр хэлэлцүүлсэн байх.

7. Төсөл боловсруулагчид тавигдах шаардлага

7.1. 2023, 2024 онуудын аль нэг жил төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх. /Ижил төстэй ажилд ил уурхайн ТЭЗҮ боловсруулсан хамруулна/ Гэрээ болон гэрээ дүгнэсэн акт, ажлын цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн тодорхойлолт ирүүлэх.

7.2. Төсөл боловсруулагч нь зураг төсөл боловсруулах ЗТ-4.7 тусгай зөвшөөрөлтэй байх, тусгай зөвшөөрлийг авснаас хойш нэгээс дээш жил тогтвортой ажилласан байх.

7.3. Уул уурхайн зураг төсөл боловсруулах чиглэлээр 5 аас доошгүй жил ажилласан байх.

7.4. Мэргэжлийн уул уурхайн программ хангамжтай байх, нотлох баримт ирүүлэх албан тоот.

7.5. 2023, 2024 онуудад ашигтай ажилласан байх.

7.6. Боловсон хүчний мэдээлэл ирүүлэх.

№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага
1	Төслийн удирдагч	1	Монгол улсын Зөвлөх инженер, Уул уурхайн ашиглалтын технологи мэргэжилтэй Бакалавр дээш зэрэгтэй. Гэрээт байж болно.	5-10 жилээс дээш ажилласан
2	Нөөцийн геологич	1	Геологич мэргэжилтэй, Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй. Гэрээт байж болно.	5-10 жилээс дээш ажилласан
3	Уул уурхайн ашиглалтын инженер	2	Уул уурхайн ашиглалтын технологи мэргэжилтэй 1 нь бакалавр дээш, нөгөө нь магистр дээш зэрэгтэй. Үндсэн ажилтан	5-10 жилээс дээш ажилласан
4	Геотехникийн инженер	1	Бакалавр түүнээс дээш зэрэгтэй, гэрээт байж болно.	5 жилээс дээш ажилласан

5	Баяжуулалтын инженер	1	Бакалавр түүнээс дээш зэрэгтэй, гэрээт байж болно.	5-10 жилээс дээш ажилласан
6	Уул уурхайн эдийн засагч	1	Бакалавр түүнээс дээш зэрэгтэй. Үндсэн ажилтан	5-10 жилээс дээш ажилласан

Хянасан:.....Ерөнхий инженер Г. Наранцогт

Боловсруулсан:.....Төлөвлөлтийн инженер Д.Эрдэнэбаяр